



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№111 /111/

2021.08.12

ҮЙЛ ЯВДАЛ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 015 ДУГААР АНГИ ТҮҮХТ 100 ЖИЛИЙН ОЙГОО ТЭМДЭГЛЭЛЭЭ



одонт Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн түүхт 100 жилийн ой өчигдөр тохиолоо.

Түүхт ойн баярын хурал Офицеруудын ордонд зохион байгуулагдсан бөгөөд тус хуралд ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал Ц.Жавхланбаатар, БХЯ-ны СБТГ-ын дарга, хурандаа С.Ганбямба, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа Ч.Гандирваа, ЗХЖШ-ын Материал техникийн газрын дарга, бригадын генерал М.Мөнхбаяр болон Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн үе үеийн удирдлага, хамт олон, ахмадууд оролцлоо.

Ангийн захирагч, хурандаа Ц.Батсайхан "Тус анги нь 1921 оны Ардын хувьсгалын үр дүнд туурга тусгаар Монгол Улсаа байгуулах, 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайн, улсын баруун хил дээр болсон зэвсэгт тулгаралтын ялалтыг авчрах үйл хэрэгт зэвсэг, галт хэрэглэлийн хангалтыг тасралтгүй зохион байгуулах үүргийг амжилттай биелүүлж ирсэн түүхтэй анги юм. Түүхийн энэхүү хугацаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудыг зэвсэглэл, галт хэрэглэл, техник хэрэгслээр тасралтгүй хангах, хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулах, засвар, үйлчилгээ хийх, зэвсгийн бага мэргэжилтэн бэлтгэх үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгаагийн зэрэгцээ

олон улсын болон хоёр талын "Хааны эрэлд", "Сэлэнгэ" сургууль, "Мэргэн буудагчийн зааг", "Зэвсгийн мастер" зэрэг тэмцээн, уралдаанд амжилттай оролцон мэдлэг, ур чадвараа сорьж, мэргэжлийн бэлтгэлээ улам дээшлүүлж байна. Ангийнхаа 100 жилийн түүхийг ажил үйлсээрээ бахархалтайгаар бүтээхэд оролцсон хурандаа Б.Ванчигравдан, Ө.Дашхүү, М.Дамдиндорж, Д.Төмөрбаатар, С.Эрдэнэбаатар, Д.Батболд, С.Түвшинбаяр захирагч нартаа болон үе үеийн ахмад дайчид, одоо албаа нэр төртэйгөөр хааж байгаа бие бүрэлдэхүүндээ ойн баярын мэндийг хүргэж эрүүл энх, аж жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе" хэмээн үндсэн илтгэлээрээ баярын хурлыг нээлээ.

Тус анги түүхт ойгоо угтаж 4 жилийн төлөвлөгөөний дагуу олон ажлыг хийж гүйцэтгэжээ. Тухайлбал, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хэмжээнд анх удаа "Жишиг ногоон байгууламжтай анги" төслийг амжилттай хэрэгжүүлж, 190 сая төгрөгийн өртөг бүхий хичээлийн байрыг ашиглалтад оруулаад байгаа юм. Мөн ангийнхаа Алдрын тасалгааг шинэчлэн тохижуулах, алба хаагчдын сургалт бэлтгэлийн түвшинг ахиулсан зэрэг олон бүтээлч ажлыг өрнүүлсэн өрнүүн их амжилттайгаар түүхт 100 жилийн ойгоо угтлаа.

Монгол Улсынхаа гал голомт, туурга тусгаар байдлыг бат найдвартайгаар батлан хамгаалж түүхэн сорилт шалгуур бүрийг

ялгуусан туг, ялалтын уухайгаар мөнхөлж, баатарлаг тэмцэл, бадрангуй үйлсээрээ дархалсан Цэргийн гавьяаны Улаан тугийн

ЭНХИЙГ САХИУЛАГЧИД ХАНДИВЫН АЯНД НЭГДЛЭЭ



Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй Нэгдсэн Үндэстний байгууллагын мандаттай "UNMISS" энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын

Зэвсэгт хүчний 10 дугаар ээлжийн батальоны Ахлагчийн зөвлөлөөс ажиллагааны газар оронд иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, хариуцлагын бүсэд "Ковид-19" цар тахлаас

урьдчилан сэргийлэх арга хэмжээг өргөжүүлэх зорилгоор "Юнити" секторын Бентью суурины төв эмнэлэгт 100 литр гар ариутгагч, 6000 ширхэг амны хаалтыг хандивлалаа.

Уг хандивыг гардуулах ёслолд батальоны захирагчийн орлогч, штабын дарга, хурандаа Ц.Батсайхан, батальоны ахлагч, тэргүүн ахлагч Б.Пүрэвсүрэн, Юнити секторын иргэн-цэргийн харилцааны офицер, хошууч Францис Себүданди нар болон Бентью суурины төв эмнэлгийн удирдлага оролцлоо.

Бентью суурины төв эмнэлгийн удирдлага "Цар тахлын үед бидний үйл ажиллагааг дэмжин нэн хэрэгцээтэй гар ариутгагч, амны хаалтыг хандивлаж байгаад Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн удирдлага, бие бүрэлдэхүүнд баярласнаа илэрхийлээд, та бүхний цаашдын энхийг сахиулах ариун үйлсэд амжилт хүсье" хэмээн онцоллоо.

Сонирхуулахад 8 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад коронавирусийн халдварын 11 мянга гаруй тохиолдол бүртгэгдсэн бөгөөд урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад нийт хүн амын 0,1 хувь нь хамрагдаад байна.

Ахлах дэслэгч Г.ЦЭРЭННАДМИД

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 24	🌧️ 10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 3	🌧️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.850.0	2.853.0
EUR 🇪🇺	3.50.0	3.360.0
CNY 🇨🇳	440.0	441.0
RUB 🇷🇺	38.20	39.40
JPY 🇯🇵	25.58	26.02
KRW 🇰🇷	2.42	2.51

ЗУРХАЙ

2021.08.12 ПҮРЭВ ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 4/

НАМРЫН ТЭРГҮҮН УЛААН БИЧ САРЫН ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХАР ЛУУ ӨДӨР

Үс засуулбал: **Бие эрхтний хүч сайжирна**
Наран ургах, шингэх: **05:43-20:11**

Барилдлага: **Хотол чуулган**
Шүтэн барилдлага: **Төрөхүй**
Суудал: **Гал**

Энэ өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой.

Эл өдөр санасан хэрэг түргэн бүтнэ. Бүтээл үйлдэх, тус чухалчлах, хэл ам дарах, башир, хатуу, түргэн үйлнээ сайн, гэрийн үйл, бие угаах, хувцас өмсөхөд сайн. Баруун нүд татвал зочин ирэх, зүүн нь татвал хувцас олох, баруун чих цангинавал баярлах, зүүн нь бол муу. Нохой уливал амгалан сайн болох, тагнай загатнавал дээрэм ирэх, бие татвал аюул болно.

ДОРНЫН ЗУРХАЙ: Үс засуулбал бие эрхтний хүч сайжирна



Могойг ХАТГУУЛАХААС СЭРГИЙЛЭ

НИКОЛИЙН СУУРШЛАН БҮСЭД СНИМЭЙ ХОНДООРГ ГЭХ ХӨРТӨЙ МӨГӨЙ ӨЖЖ ИРЭХ БОЛЖЭЭ. ХАЛДЛАГАЙ ГЭЛТЭР АНХААРЖ ЭНХЭЭ ХӨСӨЙ НЭ. ЭД ӨРЧӨН ӨН УУЛГАЙ. ӨРЧӨӨЙ ТҮГ ХҮЛ ШАЛГА КӨН УУ ХӨР ХӨТӨН АНГАТЭЭ. ИГЭҮҮ БА СУУНГАЙ ДЭГҮҮ ХАВДАН ЦАГЛАН СУДАЛТАЙ. ЭНЭ СУДАЛ ЗӨВХӨН ДЭГЭЭРЭН ТӨСӨХӨЙТӨН. БИХИЙН ХӨӨ ХӨЖҮҮГЭЭР ТУУШ ЭНЭСЭН ЦАЙРАР БАРИАН ТӨЛӨӨТӨЙ. ХҮҮХЭН ХАРИН НЬ 6000.

ИЭД ХАМРЫН ХӨӨРӨНД СҮНЭГЭЙ ХӨНӨХӨРТӨЙ ТУУЛ ЗЭВЭХ АЖИЛЛАХАД ХАМРЫН 4 СҮВЭЙ МЭТ БАЙДАГААРА БҮСЭД МӨГӨЙНООС ХӨЛӨӨР АЯЛГАДНА

- ОЙ МОД, БҮТ, ХАД, АГАЛТАЙ ГАЯАР ЯВАХДА УРТ ТҮРИЙТЭЙ ГҮТЛЭЛ, ӨМД, СӨВХИН БЭЭЛИЙ ӨМӨХ
- МӨГӨЙТӨЙ ТӨРӨВӨЛ ЧӨМӨӨ ХӨХӨЙТӨЙ, ОЦЦОН ХӨДӨЛӨГӨН ХӨЙХӨГҮЙ БАЙХ
- ӨНДӨР ӨВӨ, БҮТТЭЙ ГЭРЭЭР ЯВАХАС АЛЬ БОЛОХ ЗӨЙЛӨЙХ
- БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХАРАА ХАНАЛТҮЙ ОРХИХӨГҮЙ БАЙХ
- ХҮҮХДИЙН ТОГЛООМ, ТЭРЭГ ГЭХ МЭТИЙГ ШАЛГАХ

МӨГӨЙД ХАТГУУЛАХ ТОХИОЛДОД НЭН ЯАРАЛТАЙ ХАМГИЙН ОЙР БАЙРЛАХ ЭМНЭЛЭГТ ОЧИХ ШАРАЛДАГАЛТАЙ.

ХЭРЭВ НИЙЦЭГДЭН ЭНХЭХҮ МӨГӨЙТӨЙ ТӨРӨВӨЛ НИЙЦЭГЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАРЫН ЗӨВӨД, 32570 УТАНД ХӨЛӨГДӨХӨЙ АНХААРУУЛЖ БАЙНА.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 176,993 +1433	ЭДГЭРСЭН 159,878 +1991	НАС БАРСАН 863 +3
-----------------------------------	---------------------------	----------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4281 +78	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 176 +15	ЭДГЭРСЭН 4023 +7
-----------------------------	--------------------------------	---------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 205,430,337

Эдгэрсэн
Нийт: 184,429,798

Нас барсан
Нийт: 4,336,662

ЦАХИМ ШУУДАНД

ЭЛСНИЙ ГАР БӨМБӨГИЙН АВАРГУУД ШАЛГАРАВ



Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Ангийн сургалтын албаны бие бүрэлдэхүүн дотоод нөөц бололцоогоо ашиглан "Биеийн тамирын заавар-18"-д заасны дагуу "Биеийн тамирын хотхон"-ыг тохижуулж энэ сарын 5-ны өдөр нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа. Энэ үеэр явуулсан элсний гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд 18 баг оролцсоноос Мотобуудлагын батальоны хамт олон тэргүүн байр эзэлж, Инженерийн албаны хамт олон дэд байрт шалгарлаа.

Дэслэгч
Г.НАНДИНЧИМЭГ

"ЭХ ОРОН-100" СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Зэвсэгт хүчний 186 дугаар анги



ЧУХАЛ ШИЙДВЭР

Судалгаанаас үзэхэд наслагдсан хүн амьдралынхаа 40 жилийг сонгосон мэргэжилдээ зориулдаг байна. Ажилгүй иргэдийн 62% нь 45 аас доош насныхан, 61% нь 15-34 насны залуус байна.

Орхон аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын харьяа Залуучуудын ордонтой хамтран "Эх орон-100" сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хугацаат цэргийн алба хаагчдын дунд зохион байгууллаа.

Сургалтын үеэр 6 төрлийн сэдвээр мэдээлэл өгч, хөгжөөнт тоглоом тоглуулж, урлагийн номерууд үзүүлэв. Тус сургалтад цэргийн алба хаагчид маань маш идэвхтэй оролцсон бөгөөд мэдлэг олгосон, инээдээр дархлаагаа дэмжсэн сайхан арга хэмжээ

боллоо. Сургалтын төгсгөлд ангийн удирдлагаас хамтран ажилласан Залуучуудын ордны арга зүйч нар болон түүний дэргэдэх хөгжмийн хамтлагийн бүрэлдэхүүнд талархал илэрхийлсэн юм.

Хошууч
Т.ЗАЯАНДАРЬ

БАРВАН ЖИЛИЙН ДАРААХ АМЬДРАЛАА ТӨСӨӨЛӨН ЗУРЖ, БИЧИВ



Зэвсэгт хүчний 110 дугаар анги

Ангийн хугацаат цэргийн алба хаагчдад Орхон аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн У.Уянга "Гэр бүл төлөвлөлт,

ханиа сонгох, гэр бүл зохиох" сэдвээр сургалтыг зохион байгууллаа.

Сургалтын хүрээнд 10 жилийн дараагийн өөрийн амьдралыг төсөөлөн зурж, бичиж, хаачилбараар наах

даалгавар өгч байсан нь дээрх сургалтыг улам бүр сонирхолтой болгож алба хаагчид идэвхтэй хамрагдан халуун дулаан уур амьсгал бүрдсэн сургалт болж өнгөрсөн юм.

Дэслэгч **Б.ХАЛИУН**

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2021-2022 онд үүрэг гүйцэтгэх цэргийн ажиглагч офицер, штабын ажилтны сонгон шалгаруулалтыг 2021 оны 9 дүгээр сарын 20-ноос 24-ны өдрүүдэд зохион байгуулна.

Сонгоншалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид

2021 онд шинээр батлагдсан "Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах журам"-тай танилцаж, НҮБ-ын цэргийн

ажиглагч, штабын ажилтанд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын АУГ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ. Үүнд:

1. Харьяа анги, байгууллага, төрлийн цэргийн командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;
2. Ажил байдлын тодорхойлолт
3. Ж о л о о н ы үнэмлэхний хуулбар;

4. Цэргийн ажиглагч, штабын офицерын сургалт, дамжаа дүүргэсэн сертификатын хуулбар;

5. Сүүлийн 3 сарын дотор авахуулсан 4x6 хэмжээтэй цээж зураг 2 хувь.

6. Товч судалгаа
7. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт

Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг АУГ-ын ЭДАХ-ийн psod@mail.gov.mn цахим шуудангаар болон /3203, 92115982/-тэй холбогдож тодруулж болно.

ЗХЖШ-ЫН АУГ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

15 КМ-ИЙН ЯВГАН МАРШИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 120 дугаар анги

Ангийн сургуулийн сургалтын төлөвлөгөөний дагуу 15 км-ийн явган маршийг амжилттай зохион байгууллаа.

Маршийн хүрээнд тактик, тусгай тактик, галын бэлтгэл, инженерийн бэлтгэл,

хүн эмнэлгийн бэлтгэл, байр зүйн бэлтгэл, ҮОХЗХ бэлтгэл зэрэг 6 цэгийг дэлгэн бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх дадлага, чадварыг нэмэгдүүлэн ажиллав.

Мөн үүссэн цагийн байдалд шийдвэр гаргах, салбараа удирдах, бие

бэлдэр, сэтгэл зүйн хатуужил олгож, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын өдрийн хооллолтыг хээрийн гал тогоогоор зохион байгуулсан нь давхар ар талын бэлэн байдлыг шалгасан үр дүнтэй сургалт боллоо.

ӨНӨӨДРӨӨС ТҮЙМРИЙН УТАА БАГАСНА

ОХУ-д гарсан ойн түймрийн улмаас өнөөдрийн байдлаар Монгол орны хойд хэсэг буюу Хөвсгөл, Сэлэнгэ, Булган, Төв, Улаанбаатар мөн Өвөрхангай, Архангайн зүүн хэсэг,

Дорноговь, Өмнөговийн хойд хэсгээр түймрийн утаа тархсан.

Ө н ө ө д р и й н байдлаар агаарын урсгал баруун хойноос буюу түймрийн утаа ихтэй талаас ирэх нь

хэвээр байх аж. Харин наймдугаар сарын 12-ноос ихэнх нутгаар агаарын урсгал баруун өмнөөс болох тул түймрийн утаа багасах төлөвтэй гэж ЦУОШГ-аас мэдээллээ.

- ✓ Шаардлагагүй бол гадагш гарахгүй байх,
- ✓ Хаалга, цонхыг онгойлгохгүй байх;
- ✓ Дотоод орчинд агааржуулагч болон нарийн ширхэглэгт тоосыг шүүх (НЕРА) хүчин чадалтай агаар шүүгчийг хэрэглэх;
- ✓ Гэртээ тамхи татахгүй, мод, нүүрс түлэхгүй байх;
- ✓ Хүүхэд, жирэмсэн болон настай хүмүүс, архаг хууч өвчтэй хүмүүст анхаарал сайн тавих;
- ✓ Гадаад орчинд алхах, дугуй унах, гүйх, биеийн хүчний ачаалалтай ажлыг хязгаарлах;
- ✓ Гадагш гарахдаа N95 амны хаалт болон зориулалтын шүлтүүр бүхий маскыг зүүх;
- ✓ Гадагш гарахын өмнө Цаг Уур, Орчны Шинжилгээний Газраас гаргадаг агаарын чанарын мэдээллийг <http://www.agaar.mn/index> шалгах